

ШИНЖЭЭЧДИЙН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨСӨӨЛӨЛ (2023 оны II улирлын түүвэр судалгааны тайлан)

Судалгааны товч үр дүн

Шинжээчдийн макро эдийн засгийн төсөөллийн судалгааг 2023 оны 5 сарын 19-30-ны өдрүүдийн хооронд банкуудын эдийн засагчид, их дээд сургуулиудын багш нар болон судалгааны байгууллагууд, хөрөнгө оруулалтын менежментийн компаниудын нийт 26 судлаачид (цаашид шинжээч)-ын дунд явуулж, судалгааны үр дүнг дараах байдлаар нэгтгэн танилцуулж байна.

Шинжээчид:

2023 оны II улиралд

- Инфляц бага зэрэг өсөж 11.4%,
- Эдийн засгийн өсөлтийг буурч 5.5%,
- Төв банкны бодлогын хүү өнөөгийн түвшинд тогтвортой байж 12.9%,
- Зээлийн хүү өнөөгийн түвшинд тогтвортой байж 16.5%,
- Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийг бага зэрэг чангарч 3,469.8 төгрөг болно гэж таамагласан байна.

2024 оны I улиралд

- Инфляц буурч 10.5%,
- Эдийн засгийн өсөлтийг буурч 5.4%,
- Төв банкны бодлогын хүү бага зэрэг буурч 11.9%,
- Зээлийн хүү бага зэрэг буурч 16.1%,
- Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийг нэлээд суларч 3,572.8 төгрөг болно гэж таамагласан байна.

Судалгааны нэгдсэн үр дүн

Огноо	2023 он 4 сар	2023 он II улирал	2024 оны I улирал
Инфляц /ХҮИ-ийн жилийн өсөлт, УБ хот, %/	10.9%	11.4%	10.5%
Эдийн засгийн өсөлт /Бодит ДНБ-ий жилийн өсөлт, %/	7.9%	5.5%	5.4%
Төв банкны бодлогын хүү /%/	13.0%	12.9%	11.9%
Олгосон зээлийн дундаж хүү /₮, %/	16.9%	16.5%	16.1%
Төгрөгийн ам.доллартай харьцах ханш /Хугацааны эцэст/	3,475.7₮	3,469.8₮	3,572.8₮


Энэхүү улирал тутмын түүвэр судалгааны тайлангийн агуулга нь зөвхөн банкууд, хувь шинжээч, судлаачдын таамаглалыг нэгтгэсэн үр дүнг илэрхийлэх бөгөөд Монголбанкны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

© МОНГОЛБАНК, 2023

I. Инфляц


2023 оны I улиралд Улаанбаатар хотын жилийн инфляц 10.9% болж буурсан бөгөөд энэ нь өмнөх улирлын шинжээчдийн дундаж таамаглалаас 1.6 нэгж хувиар доогуур гарсан байна. Шинжээчид 2023 оны II улиралд инфляц 11.4%, жилийн дараа бага зэрэг буурч 10.5% болно гэж таамаглаж байна (Зураг 1).

Зураг 1. Инфляцын таамаглал





Шинжээчдийн инфляцын таамаглалын тархалтыг авч үзвэл 2023 оны II улиралд инфляц 10-аас 10.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 29.1%-тай байна. Өмнөх улирлын судалгаагаар 2023 оны II улиралд инфляц 12-оос 12.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 28.8% гэж таамаглаж байжээ (Зураг 2).

Зураг 2. Инфляцын таамаглалын тархалт /2023.II улирал/



Энэ удаагийн инфляцын таамаглалын нэг үеийн үр дүнг өмнөх түүвэр судалгаануудын таамаглалуудтай харьцуулахад буурах хандлага ажиглагдаж байна. Сүүлийн саруудад инфляц тогтворжин, буурч байгаатай холбоотойгоор шинжээчдийн инфляцын таамаглал буурсан байх талтай. Тухайлбал, шинжээчид 2023 оны II улирлын инфляцыг өмнөх улирлын судалгаагаар 12.3% гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 11.4% гэж таамаглажээ (Зураг 3).


Зураг 3. Инфляцын өмнөх таамаглалуудын харьцуулалт



II. Эдийн засгийн өсөлт


2023 оны I улиралд бодит ДНБ-ий жилийн өсөлт 7.9%-д хүрсэн бөгөөд энэ нь өмнөх улирлын шинжээчдийн дундаж таамаглалаас 4.0 нэгж хувиар өндөр гаржээ. Ирэх улирлын эдийн засгийн өсөлтийн шинжээчдийн дундаж таамаглал 5.5%, жилийн дараа 5.4%-тай байна (Зураг 4).

Зураг 4. Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглал




Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглалын тархалтыг авч үзвэл 2023 оны II улиралд 5-аас 5.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 23.9% байна. Харин өмнөх улирлын судалгаагаар өсөлт 4-өөс 4.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 26.3% байна гэж таамаглаж байжээ (Зураг 5).

Зураг 5. Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглалын тархалт /2023.II улирал/




Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглалыг өмнөх түүвэр судалгаануудын таамаглалуудтай харьцуулан авч үзвэл өсөх хандлага харагдаж байна. 2022 оны дунд үеэс эдийн засгийн байдал сэргэж эхэлснээс үүдэн шинжээчдийн эдийн засгийн өсөлтийн таамаглал улирал бүр нэмэгдэж иржээ. Жишээлбэл, шинжээчид 2023 оны II улирлын бодит ДНБ-ийн өсөлтийг өмнөх улирлын судалгаагаар 4.1%-д хүрнэ гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 5.5% гарна гэж таамаглажээ (Зураг 6).

Зураг 6. Бодит ДНБ-ий өсөлтийн өмнөх таамаглалуудын харьцуулалт




Тархалтын дундаж утга Бодит ДНБ-ий өсөлт
Тоон хариултын дундаж Тоон хариултын медиан



Ш. Бодлогын хүү


Шинжээчид төв банкны бодлогын хүүг 2023 оны II улиралд дунджаар 12.9%, хамгийн ихдээ 14.0%, хамгийн багадаа 12.0% байна гэсэн хүлээлттэй байна. Цаашид бодлогын хүү бага зэрэг буурч 2024 оны I улиралд 11.9% байна гэж таамагласан байна (Зураг 7).

Зураг 7. Бодлогын хүүний таамаглал



Бодлогын хүүний таамаглалыг тархалтаар нь авч үзвэл шинжээчдийн дийлэнх нь 2023 оны II улиралд бодлогын хүү 13.0% байна гэсэн таамаглалтай байна (Зураг 8).


Зураг 8. Бодлогын хүүний таамаглалын тархалт /2023. II улирал, хариултын тоогоор/



Бодлогын хүүний таамаглалыг өмнөх улирлын судалгааны таамаглалуудтай харьцуулахад буурах хандлагатай байна. 2022 оны эхэн үеэс үнийн өсөлтийг хязгаарлах зорилгоор бодлогын хүүг нэмэгдүүлж эхэлсэнтэй холбоотойгоор шинжээчдийн таамаглал улирал бүр нэмэгдэж ирсэн бол энэ улирлаас буурах хандлага

ажиглагдлаа. Өмнөх улирлын судалгаагаар шинжээчид 2023 оны II улирлын бодлогын хүүг 13.0% байна таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 12.9% байна гэж таамаглажээ. Энэ нь 2022 оны III улирлын түүвэр судалгааны таамаглалаас 2.2 нэгж хувиар өндөр байгаа боловч цаашид аажмаар буурахаар таамаглажээ (Зураг 9).


Зураг 9. Бодлогын хүүний өмнөх таамаглалуудын харьцуулалт



IV. Зээлийн хүү


Шинжээчид төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүүг 2023 оны II улиралд дунджаар 16.5%, хамгийн ихдээ 18.0%, хамгийн багадаа 14.8%-тай байна гэжээ. Цаашид зээлийн хүү бага зэрэг буурч 2024 оны I улиралд 16.1% орчим байхаар таамагласан байна (Зураг 10).

Зураг 10. Зээлийн хүүний таамаглал




Зээлийн хүүний таамаглалын тархалтаас харвал 2023 оны II улиралд зээлийн жигнэсэн дундаж хүүг 15.9%-16.8% байна гэсэн таамаглал давамгайлж байна (Зураг 11).

Зураг 11. Зээлийн хүүний таамаглалын тархалт /2023.II улирал, хариултын тоогоор/



Зээлийн хүүний таамаглалыг өмнөх түүвэр судалгаануудын үр дүнтэй харьцуулан авч үзвэл бага зэрэг өсөх хандлага харагдаж байна. Бодлогын хүү нэмэгдэж байгаатай холбоотойгоор шинжээчдийн зээлийн хүүний таамаглал улирал бүр нэмэгдэж иржээ. Тухайлбал, өмнөх улирлын судалгаагаар шинжээчид 2023 оны II улиралд зээлийн хүүг 16.3%-д хүрнэ гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 16.5% гарна гэж үзжээ (Зураг 12).


Зураг 12. Зээлийн хүүний өмнөх таамаглалуудын харьцуулалт



V. Валютын ханш


Шинжээчид 2023 оны II улиралд төгрөгийн ам.доллартай харьцах ханш бага зэрэг чангарч дунджаар 3,469.8 төгрөг, хамгийн ихдээ 3,591.8 төгрөг, хамгийн багадаа 3,388.8 төгрөг байна гэж үзжээ. Цаашид төгрөгийн ханш суларч 2024 оны I улиралд 3,572.8 төгрөгт хүрнэ гэж таамаглажээ (Зураг 13).

Зураг 13. Ханшийн таамаглал



Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн таамаглалыг тархалтаар нь авч үзвэл шинжээчдийн дийлэнх нь ханш 2023 оны II улиралд 3,440.1-3,490.0 төгрөг байна гэж хариулжээ (Зураг 14).

Зураг 14. Ханшийн таамаглалын тархалт /2023.II улирал, хариултын тоогоор/



Шинжээчид 2023 оны II улирлын төгрөгийн ам.доллартай харьцах ханшийг өмнөх 2 улирлын түүвэр судалгааны үр дүнтэй харьцуулахад бага зэрэг чангарахаар таамагласан байна (Зураг 15).

Зураг 15. Ханшийн өмнөх таамаглалуудын харьцуулалт

